

Хоёр дахь хэл чех хэлтэй сурагчдын хэлний сургалтын дэмжлэг

Хэлний сургалтын дэмжлэг (Боловсролын Актын 16-р хэсгийн дагуу)

Шинээр ирсэн гадаад сурагч нар хуулийн дагуу гадаад хэлийг чөлөөтэй сурах эрхтэй. Гэхдээ Чех улсад удаан хугацаагаар амьдарсан сурагч нар чех хэлээр чөлөөтэй харьцаж чадах, чех хэл дээр өгөгдсөн хүнд хэцүү даалгавар болон бусад хичээлүүдийг чөлөөтэй ойлгож чадах уу? Тэд нар дэмжлэг авах эрхтэй юу? Хэрэв тийм бол, ямар дэмжлэг авах вэ? Эсвэл 20-р Хэсгийн дагуу хэл сурах хичээл зохион байгуулахад хичээлийн хүндрэлтэй, сул сурагч нартай ажиллах байдлаар тэдэнтэй ажиллах уу (хэрэв тэд сургуульдаа ганцаараа байвал)?

Хэлний мэдлэг дутуу хүүхдүүдийг 2016 оны 9-р сараас Боловсролын Акт ба Хэрэгжүүлэлтийн Зохицуулалтанд (тусгай боловсрол хэрэгцээтэй ба хэт авьяслаг хүүхдүүдийн боловсролын тухай 27/2016 Тогтоол) нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тусгай боловсрол авах хэрэгцээтэй хүүхдүүд (SEN) гэж тооцно.

Дэмжлэгийн арга хэмжээ шинэ таван шатлалтай тогтолцоотой, хоёр дахь хэл чех хэлтэй сурагчдын хэлний дэмжлэг нь голцуу дэмжлэгийн хоёрдугаар ба гуравдугаар шатад хамаарна. Хоёр тохиолдолд хоёуланд хэрэв хэрэгцээтэй бол сургуулийн зөвлөлийн байгууллагын (SCF) зөвлөгөө авах шаардлагатай. Ийм тохиолдолд SCF-ээр шалгалт авахуулах хүсэлт гаргах ба дэмжлэгийн арга хэмжээг зөвшөөрч байгаа эцэг эх нарт мэдэгдэх ёстой!

Дэмжлэгийн арга хэмжээнд хамрах хүүхдүүд ямар эрхтэй вэ?

Дэмжлэгийн арга хэмжээний 2-р үе шат

2-р үе шат нь **зааварчилгааны хэлний мэдлэг нь хүрэлцэхгүй хүүхдүүдийг** хамаарна (B1–B2 зэрэглэлийн чех хэлтэй).

Санал болгож байгаа дэмжлэгийн арга хэмжээнүүд:

- Тусгай хэл сурах номоор хангах ба туслалцаа үзүүлэх (гадаад иргэдэд зориулсан чех хэлний ном);
- Долоо хоногт нэг удаа 1 цагийн **сурган хүмүүжүүлэх хичээл** заах (сурагчтай ажиллах эсвэл сургуульд ангид нь хичээл заах) – хоёр дахь хэл чех хэлийг голчлон заах;
- Сургуулийн **тусгай сурган хүмүүжүүлэгч заах тусгай сурган хүмүүжүүлэх хичээлийг** долоо хоногт 1 цаг заана.

Бага ба дунд сургуулийн зан заншил ба амьдралын байдал эрс өөр нөхцөлтэй хүүхдүүдэд зориулсан дэмжлэг үзүүлэх нь сурагчдад чех хэл заах явцыг сайжруулахаар чех хэлийг сурагчийн хоёр дахь хэл (CSL) болгож **аль болох олон цагаар зайлшгүй хэлний хичээл сургалт** явуулах, сурагчид долоо хоногт 3 цагийн **CSL-ийн** хичээл заалгах эрх олгох, **хамгийн дээд хэмжээ нь жилд 120 цагийн сургалт хийхэд оршино.**

Дэмжлэгийн арга хэмжээний 3-р үе шат

3-р үе шатны дэмжих арга барил нь **зааварчилгааны хэлний огт мэдлэггүй** сурагчдыг хамаарна (A0–A2 зэрэглэлийн чех хэлтэй).

Санал болгож байгаа дэмжлэгийн арга хэмжээ:

- Сургалтын агуулгыг зохицуулах,
- Тусгай номоор хангах ба туслалцаа үзүүлэх (гадаад иргэдэд зориулсан чех хэлний ном);
- Долоо хоногт сурган хүмүүжүүлэх 3 цагийн хичээл заах (ангитайгаа долоо хоногт 1 удаа хичээллэх) – жишээ нь, CSL-ийн дэмжлэг үзүүлэх;
- Сургуулийн тусгай сурган хүмүүжүүлэгчийн заах долоо хоногт 3 удаа тусгай сургалтын хичээл, эсвэл, хэрэгцээтэй тохиолдлуудад, сэтгэл зүйчийн туслалцаа авах;
- 0.5 FTE-ийн (энэ нь чех хэл хоёр дахь хэл мэт заах тусгай мэргэжилтнийн хичээлд суух байж болох юм) хүрээнд өөр нэгэн сурган хүмүүжүүлэгчийн сургалт дэмжлэг авах. Бага ба дунд сургуульд чех хэлийн мэдлэгээ дээшлүүлэх хэрэгцээтэй хүүхдүүдэд долоо хоногт **3 цагийн хэлний хичээл заах, жилдээ 200 цагаас илүү** заахаар төлөвлөнө.
- 3-р үе шатны дэмжлэгийн хэсэг болох нэгэн гол зүйл бол сурагч зөвлөх төвийн зохих зөвлөгөөг **сургуулиас гадуур байдалтай** авч болох юм. 27/2016 тогтоолыг харна уу “Хэрэв тусгай боловсрол хэрэгцээтэй тохиолдолд (ялангуяа **эрс өөр зан заншилтай орчноос** ирсэн хүүхдүүд, эсвэл эрс өөр ахуй амьдралын маягтай сурагчид) энэ нь боломжтой, хэрэв хэрэгцээ гарвал, **бага сургуульд суралцах хугацааг**, мөн дунд сургууль ба мэргэжлийн боловсролыг нэг жилээр сунгаж болно.” Энэ нь Чех улсад ирээд **9-р ангид орж байгаа**, гэхдээ хэл мэдэхгүй шалтгаанаар амжилтгүй суралцсан сурагчдад хамаарна. Гэхдээ бид ийм тохиолдлуудад сурагчдыг бага сургуулийн шалгалтыг өгөөд **нэг жилээр доош** ангид орохыг зөвлөдөг.

4-р ба 5-р үе шатны дэмжлэгийн арга хэмжээ нь CSL-тай ба тахир дутуу байдалтай хүүхдүүдэд хамаарна.

Бага сургууль

Боловсролын Актын дагуу хүүхэд бүр боловсролд хамарч, чөлөөтэй суралцах боломжтой байх ёстой. Сургууль нь Чех улсын нутаг дэвсгэр оршин суугаа гадаад иргэдэд тэднээс хууль ёсоор оршин суух албан ёсны нотолгоо шаардахгүйгээр Чех улсын иргэдтэй нэгэн адил бага сургуулийн боловсрол олгох үүргийг хүлээнэ.

Бүх гадаад иргэд бага сургуулийн боловсролд төлбөргүй хамаарах эрхтэй, сургуулийн хоол ба сургуулийн байгууллагадөөрийн сонирхлын дагуу боловсрол авах эрхтэй. Сургууль нь CSL нөхцөл байдалтай сурагчдыг ямар нэгэн шаардлагаар буцаах ёсгүй. CSL-тай хүүхдүүдийг хүлээн авахгүй нэг шалтгаан бол сургуулийн хүчин чадал хүрэхгүйд оршино. Бид энэ хүүхдүүдийг хүлээн авах нөхцөл болзолтой сургуулиудын иймэрхүү тохиолдлуудыг хадгалсан. Энэ бол Боловсролын Актыг зөрчиж байгаа гэж үзнэ.

48/2005 (Хэсэг 10) Тогтоол нь сургуулийн тэргүүлэх багшаас сурагчийн хууль ёсны төлөөлөгчид **сурагчийг сургууль орсноос долоо хоногийн дотор** хэлний бэлтгэл хийх ангид орох боломжийг тайлбарлахыг хүснэ. Өөрөөр хэлбэл, сургууль нь сурагчдыг ийм ангид оруулах үүргийг хүлээнэ.

Боловсролын Актын 561/2004 нэмэлт өөрчлөлтийн дагуу ба 27/2016 Тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу CSL-тай сурагчдын дэмжлэг нь хүүхдүүдэд маш их өөрчлөлт авчирдаг ба ангидаа дэмжлэг хэрэгцээтэй сурагчдад зохих нөлөө үзүүлдэг. Энэ нь **чех хэл хоёр дахь хэлтэй хүүхдүүд ба сурагчдыг** хамарна.

Сургуульд дасан зохицолт ба эх хэлээ сурахад үнэгүй дэмжлэг үзүүлэх

Орон нутгийн эрх мэдэлтэй хэсгийн захиргаа нь хүүхдийн оршин суугаа газрыг анхаарч үзэнгээ сургуулийн туслалцаатай доорх байдлуудыг батална:

(а) бага сургуульд орох үнэгүй бэлтгэл, үүнд сурагчдын хэрэгцээг хангах чех хэлийг заах үйлдлийг оруулна,

(б) зохих хэсгүүдэд, сурагчийн гарал эх нутагтай холбоотой, түүний эх хэл ба нутгийнх нь ёс заншил зэргийг зааж сурахад нь дэмжлэг үзүүлэх, үүнийг бага сургуульд байнга заах хичээл мэт зохицуулна.

2012 оны 1-р сард 472/2011 дугаарын Боловсролын Актын нэмэлт өөрчлөлт хүчинтэй болсон. Энэ нь 2012 оны 1-р сараас зайлшгүй бүрэн боловсролын сургуульд орсон бүх гадаад сурагчид орон нутгийн захиргаатай хамтарч сурагчийн оршин суугаа газар ба сургуулийн үүсгэн байгуулагчтай хамтран ажиллаж, тэдний бага сургуулийн боловсролын тогтолцоонд дасан зохицох ажиллагааг бэлдэх ба чех хэлийг сурагчийн хэрэгцээнд зохицуулан заах заалт нэмж орсон байна.

Хүүхдүүдийг сургах сурган хүмүүжүүлэх багийн боловсролыг харгалзаж, орон нутгийн захиргаа нь энэ үйл ажиллагаанд бэлдэх ёстой. Сурган хүмүүжүүлэх ажилтнууд хүүхэд ба сурагчдад заахад хэрэгцээтэй зохих боловсролыг эзэмших ёстой – жишээлбэл, гадаадууд Цаашдын Боловсролын Үндэсний Институтад гэхчлэн.

Цагаачлал орогнол хайгчдын байранд амьдарч байгаа хүүхдүүд ба орогногчдын байраас гадуур амьдрах хүүхдүүдийн бага сургуулиудад мөн адил хүүхдүүдийг бэлдэхээр хэлний боловсрол олгохоор заагдсан.

Хууль зүйн үндсэн хүрээ

Үндсэн эрх нь бүх хүмүүст тэдний хүйс, арьсны өнгө, хэл, шашин, итгэл, улс төрийн эсвэл өөр ямарваа нэгэн үзэл бодол, үндэстэн, гарал үүсэл, үндэсний болон угсаатны цөөхүүл хэсэгт хамрах байдал, эзэмшил, хүйс ба өөр нэгэн байдлыг харгалзахгүйгээр олгогдсон. Энэ нь Чех улсын иргэд ба гадаадын иргэдэд адил хамааралтай. Үндсэн эрх нь одоогийн хүчин төгөлдөр буй хуулинд тусгагдсан.

Хуулийн хүрээний ажиллагаа доорх хэсгүүдээс бүтнэ:

- Чех улсын Үндсэн Хуулийн 10-р Зүйлийн олон улсын конвенц (Хүний Эрхийг Хамгаалах Конвенц ба Суурин Эрх Чөлөө, Хүүхдийн Эрх Хамгаалах Конвенц, Орогнол Цагаачлалын Конвенц гэх мэт)
- Үндсэн эрх ба эрх чөлөөний Дүрэм – Европын хууль зүй (зохицуулалт ба чиглэлүүд)
- Гадаад иргэдийн Оршин Суух тухай Акт
- Орогнол Цагаачлалын Акт
- Түр Зуур Хамгаалах Акт
- Боловсролын Акт – хамаарах актууд, тогтоолууд, яамны зааварчилгаа.

Гадаадын иргэдийн оршин суух газрыг харгалзсан тусгай эрх ба хариуцлагуудын доорх хуулиас харж болно:

- Цагаачлалын Акт
- Түр зуурын Хамгаалалтын Акт
- Гадаад иргэдийн Оршин Суух тухай Акт